



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 05 сарын 06 өдөр

Дугаар А/339

Булган сум

**Хяналт шалгалтын арга хэмжээ
зохион байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1, 16.2.4, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.6, Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.1, Ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3, Усны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.11 дэх заалт, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.12 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны “Хяналт шалгалтын 2026 оны төлөвлөгөө батлах тухай” 184 дүгээр тогтоол, 2026 оны “Салбарын хяналт шалгалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” 115 дугаар тогтоол, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 оны “Хяналт шалгалтад хамрагдах объектын жагсаалт батлах тухай” А/955 дугаар тушаал, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны “Булган аймгийн 2026 оны төсөв батлах тухай” XII/90 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль орчны салбарын 2026 оны хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсан 25 объектод төлөвлөгөөт хяналт шалгалт, байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй иргэн, аж ахуйн нэгжид урьдчилан сэргийлэх шалгалтыг 2026 оны 05 дугаар сарын 18-ны өдрөөс 2026 оны 10 дугаар сарын 31-ний өдрийг дуустал маршрутын дагуу зохион байгуулсугай.

2. Хяналт шалгалтын удирдамжийг 1 дүгээр, замын маршрут, шаардагдах зардлын тооцоог 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Дээрх арга хэмжээнд шаардагдах зардал 18,526,496 (арван найман сая таван зуун хорин зургаан мянга дөрвөн зуун ерэн зургаа) төгрөгийг Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Б.Очирсүрэн)-д зөвшөөрсүгэй.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтийг удирдамж, төлөвлөгөөнд заасны дагуу зохион байгуулж, шаардагдах хүн хүч, техник хэрэгслээр тухай бүрд нь хангаж,

гүйцэтгэлд хяналт тавьж хамтран ажиллахыг аймгийн Аймгийн Засаг даргын тамгын газрын Салбарын хяналт, зохицуулалтын хэлтсийн дарга (Г.Давааням), Байгаль орчны газрын дарга (А.Гантөмөр), Цагдаагийн газрын дарга (Цагдаагийн хурандаа Б.Эрдэнэбилэг), сумын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Д.ПҮРЭВ-ОЧИР



ХЯНАЛТ ШАЛГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН УДИРДАМЖ

Нэг. Шалгалтын зорилго

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны “Хяналт шалгалтын 2026 оны төлөвлөгөө батлах тухай” 184 дүгээр тогтоол, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 оны “Хяналт шалгалтад хамрагдах объектын жагсаалт батлах тухай” А/955 дугаар тушаалыг үндэслэн жагсаалтад багтсан 25 аж ахуйн нэгжид төлөвлөгөөт хяналт шалгалт, байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа эрсдэл үүсэж болзошгүй иргэн, аж ахуйн нэгжүүдэд урьдчилан сэргийлэх шалгалтыг Байгаль орчныг хамгаалах тухай багц хуулиуд болон тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журам, стандартын хэрэгжилтийг шалгаж, зөрчил дутагдал гарахаас урьдчилан сэргийлэх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах цаашид авах арга хэмжээний саналыг холбогдох байгууллагуудад тавьж шийдвэрлэх, зөвлөн туслахад хяналт шалгалтын зорилго оршино.

Хоёр. Шалгалтын хүрээ, шалгалтад хамрагдах аж ахуйн нэгж, байгууллага, иргэн, объектын нэр, хамрагдах асуудал

Төлөвлөгөөт хяналт шалгалт:

Төлөвлөгөөт хяналт шалгалтад Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 оны “Хяналт шалгалтад хамрагдах объектын жагсаалт батлах тухай” А/955 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан 25 объект хамрагдана.

Төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдах объектыг байгаль орчны чиглэлээр дараах хяналтын хуудсаар эрсдэлийг үнэлэн хууль тогтоомжийн хэрэгжилтийн түвшнийг тогтооно.

01.1.4 кодтой “Үйлдвэрлэл, үйлчилгээ үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх байдлыг шалгах хяналтын хуудас,

01.2.2 кодтой “Ойн нөхөрлөл, мэргэжлийн байгууллагын мод бэлтгэлийн үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас”-аар тус тус эрсдэлийг үнэлэх, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах.

Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт:

Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтад байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, хуулийн этгээд хамрагдана.

Амьтны тухай хуулиар заасан агнуурын амьтныг агнах, барихыг хориглосон хугацаанд хууль бус ан, агнууртай тэмцэх,

Ан агнуурын холбоотой үйл ажиллагаанд Амьтны тухай хууль тогтоомжид заасан зөвшөөрөл /эрхийн бичиг, тусгай зөвшөөрөл, гэрээ г.м/ гарал үүслийн тодорхойлолт болон бусад баримт бичигт хяналт шалгалт хийх,

Амьтны тухай хуулиар заасан хориглосон арга, зэвсэг хэрэгсэл, үйл ажиллагаанд хяналт тавих,

Хууль бусаар мод, ойн дагалт баялаг бэлтгэх, худалдах, худалдан авах, тээвэрлэх байдалд урьдчилан сэргийлэх шалгалт хийх,

Ойн тухай хуулийн 26 дугаар зүйлийн хэрэгжилт, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж байгаа байдалд хяналт тавих,

Тухайн орон нутагт ойн сан бүхий газрыг гэрээгээр эзэмшиж мод бэлтгэлийн үйл ажиллагаа явуулж байгаа ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, ойн мэргэжлийн байгууллагуудад шалгалт хийх,

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээтэй эсэх, үнэлгээгээр тавигдсан нөхцөл шаардлагыг биелүүлж ажилласан эсэх,

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөтэй эсэх, төлөвлөгөөний биелэлтийг тогтоосон хугацаанд мэдээлж, тайлагнасан эсэх,

Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4, 28.6-д тус тус заасан ус ашиглах дүгнэлт, зөвшөөрөл авсан эсэх,

Усны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1, 31 дүгээр зүйлийн 31.1-д тус тус заасан ус, рашааны нөөц ашигласны болон ус бохирдуулсны төлбөр төлсөн эсэх,

Усны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4-д заасан Цооног, ерөмдөг худаг гаргах зөвшөөрөл авсан эсэх,

Усны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4-д заасан Ус авах цэг, газар доорх усны цооног, шугам хоолой тус бүр тоолуур суурилуулсан эсэх,

Усны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дэх хэсэг, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгүүдийн хэрэгжилт,

Усны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1, 30.1.2, 30.1.3, 30.2.1, 30.2.2, 30.2.3, 30.4, 30.6-д тус тус заасан ус ашиглагчийн үүрэг, ус ашиглагчид тавигдах шаардлагын хэрэгжилт,

Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны А/138 тушаалаар батлагдсан "Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал"-ын дагуу хийсэн эсэх,

Техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлыг "Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага" MNS 5917:2008, "Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага" MNS 5918:2023 стандартын дагуу хийсэн эсэх,

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны А/439 тоот тушаалаар батлагдсан актын дагуу нөхөн сэргээлт хүлээн авсан эсэх,

Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага стандартын хэрэгжилт,

Хүрээлэн буй орчин. Усны чанар. Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус Ерөнхий шаардлага MNS 6561:2024, "MNS 4943:2015 Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага" стандартын хэрэгжилт,

Хог хаягдлын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрх үүргийн хэрэгжилт,

Хог хаягдлын тухай хуулийн 23, 25, 26, 33, 34, 35 дугаар зүйлд заасан аюултай хог хаягдлыг савлах, түр хадгалах, тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгахад тавигдах шаардлагын хэрэгжилтийг тус тус шалгана.

Гурав. Шалгалтын төрөл

Төлөвлөгөөт болон урьдчилан сэргийлэх хяналт шалгалт

Дөрөв. Шалгалтын арга

Хяналт шалгалтыг Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 479 дүгээр тогтоолоор батлагдсан “Хяналт шалгалт хийх нийтлэг журам”-д заасан аргаар, батлагдсан удирдамжийн хүрээнд хийж гүйцэтгэнэ.

Тав. Шалгалтын бүрэлдэхүүн байгууллага

Уул уурхайн чиглэлээр хийх төлөвлөгөөт шалгалт:

Аймгийн Засаг даргын тамгын газар

Байгаль орчны газар

Татварын газар

Сумын Засаг даргын тамгын газар

Шатахуун түгээх станцад хийх төлөвлөгөөт шалгалт:

Аймгийн Засаг даргын тамгын газар

Байгаль орчны газар

Сумын Засаг даргын тамгын газар

Амьтны тухай хуулийн хэрэгжилтэд хийгдэх шалгалт:

Байгаль орчны газар

Цагдаагийн газар

Сумын Засаг даргын тамгын газар

Ойн мэргэжлийн байгууллагад хийгдэх шалгалт:

Байгаль орчны газар

Цагдаагийн газар

Сумын Засаг даргын тамгын газар

Орхон аймагтай хил залгаа сумдын мод бэлтгэлд хийгдэх шалгалт:

Байгаль орчны газар

Цагдаагийн газар

Сумын Засаг даргын тамгын газар

Зургаа. Шалгалт эхлэх болон дуусах хугацаа

Шалгалтыг 2026 оны 05 дугаар сарын 18-ны өдрөөс 10 дугаар сарын 31-ний өдрийг дуустал маршрутын дагуу зохион байгуулна.

Долоо. Шалгалтын дүнг танилцуулах

Хяналт шалгалтын хүрээнд зохион байгуулсан ажлын танилцуулгыг аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Аймгийн Засаг даргын тамгын газарт танилцуулж, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны салбарын хяналтын газарт хүргүүлнэ.

Найм. Өмнө хийсэн шалгалтын талаарх мэдээлэл

2025 онд төлөвлөгөөт болон урьдчилан сэргийлэх, төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг аймгийн хэмжээнд зохион байгуулж, шалгалтаар 2 зөрчлийг бусад

байгууллагад харьяаллын дагуу шилжүүлж, байгаль орчны эсрэг зөрчил гаргасан 53 иргэн, хуулийн этгээдийн гаргасан зөрчилд 32,850,000 төгрөгийн шийтгэл оногдуулж аймаг, сумын төрийн сангийн дансанд, 60,332,875 төгрөгийн нөхөн төлбөр оногдуулж Байгаль орчин, уур амьсгалын санд тус тус төвлөрүүлсэн.

--o00o--

Аймгийн Засаг даргын 2026 оны
 05 дугаар сарын 06-ны/ний өдрийн
 А/339 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт



**УУЛ УУРХАЙН ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА
 АЖ АХУЙН НЭГЖ, НӨХӨРЛӨЛҮҮДЭД ТӨЛӨВЛӨГӨӨТ ХЯНАЛТ
 ШАЛГАЛТ ХИЙХ ЗАМЫН МАРШРУТ, ЗАРДАЛ**

д/д	Сумын нэр	Зай /км/	Норм /л/ Бензин	Шатахууны хэмжээ /л/	Нэгжийн үнэ төг	Нийт үнэ /төг/
1	2	3	4	5	6	7
1 удаа явах шалгалтын зардал						
1	Булган-Бүрэгхангай-Булган	160	19.4	31	2720	84,320
2	Бүрэгхангай сумын нутаг дэвсгэрт	400	19.4	77.6	2720	211,072
Дүн		560		108.6		295,392
6, 7, 8 сард зохион байгуулах төлөвлөгөөт хяналт шалгалтад зарцуулагдах зардал						
д/д	Зардал	Зарцуулах		Нэг бүрийн өртөг	Нийт өртөг	
1	3 удаа хяналт шалгалт хийх шатахуун	1680/100*19.4=325.9		2720 төг	886,448	
2	Томилолт хүн/өдөр	5 хүн * 9 хоног =45		90000 төг	4,050,000	
Дүн					4,936,448	

**ШАТАХУУН ТҮГЭЭХ СТАНЦУУДАД ТӨЛӨВЛӨГӨӨТ ХЯНАЛТ
 ШАЛГАЛТ ХИЙХ ЗАМЫН МАРШРУТ, ЗАРДАЛ**

д/д	Сумын нэр	Зай /км/	Норм /л/ Бензин	Шатахууны хэмжээ /л/	Нэгжийн үнэ төг	Бүгд үнэ /төг/
1	2	3	4	5	6	7
1	Булган – Рашаант	220	19.4	42.6	2720	115,872
2	Рашаант - Хишиг- Өндөр	142	19.4	27.5	2720	74,800
3	Хишиг-Өндөр - Булган	68	19.4	13.1	2720	35,632
4	Булган-Хутаг-Өндөр	148	19.4	28.7	2720	78,064
5	Хутаг-Өндөр - Булган	148	19.4	28.7	2720	78,064
Дүн		726		140.6		382,432
7 сард зохион байгуулах төлөвлөгөөт хяналт шалгалтад зарцуулагдах зардал						
д/д	Зардал	Зарцуулах		Нэг бүрийн өртөг	Нийт өртөг	
1	Шатахуун	726/100*19.4=140.7 л		2720 төг	382,432	
2	Томилолт хүн/өдөр	3 хүн * 5 хоног =15		90000 төг	1,350,000	
Дүн					1,732,432	

**АМЬТНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД
 УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ ЗАМЫН
 МАРШРУТ, ЗАРДАЛ**

д/д	Сумын нэр	Зай /км/	Норм /л/ Бензин	Шатахууны хэмжээ /л/	Нэгжийн үнэ төг	Бүгд үнэ /төг/
1	2	3	4	5	6	7
1	Булган –Орхон	25	19.4	4.8	2720	13,056
2	Орхон сумын нутгаар	100	19.4	19.4	2720	52,768
3	Орхон - Хишиг-Өндөр	45	19.4	8.7	2720	23,664
4	Хишиг-Өндөр сумын нутгаар	150	19.4	29.1	2720	79,152
5	Хишиг-Өндөр - Могод	60	19.4	11.6	2720	31,552
6	Могод сумын нутгаар	400	19.4	77.6	2720	211,072
7	Могод - Сайхан	130	19.4	25.2	2720	68,544

8	Сайхан сумын нутгаар	500	19.4	97	2720	263,840
9	Сайхан - Баян-Агт	70	19.4	13.5	2720	36,720
10	Баян-Агт сумын нутгаар	400	19.4	77.6	2720	211,072
11	Баян-Агт - Булган	150	19.4	29.1	2720	79,152
Дүн		2030		393.6		1,070,592
7 сард зохион байгуулах урьдчилан сэргийлэх хяналт шалгалтад зарцуулагдах зардал						
д/д	Зардал	Зарцуулах		Нэг бүрийн өртөг	Нийт өртөг	
1	Шатахуун	2030/100*19.4=393.9 л		2720 төг	1,070,592	
2	Томилолт хүн/өдөр	4 хүн * 12 хоног =48		90000 төг	4,320,000	
Дүн						5,391,408

ОЙН МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГУУДАД ТӨЛӨВЛӨГӨӨТ ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ ЗАМЫН МАРШРУТ, ЗАРДАЛ

д/д	Сумын нэр	Зай /км/	Норм /л/ Бензин	Шатахууны хэмжээ /л/	Нэгжийн үнэ төг	Бүгд үнэ /төг/
1	2	3	4	5	6	7
1	Булган - Тэшиг	246	19.4	47.7	2720	129,744
4	Тэшиг сумын мод бэлтгэлийн талбай	200	19.4	38.8	2720	105,536
5	Тэшиг - Булган	246	19.4	47.7	2720	129,744
6	Булган - Сэлэнгэ	135	19.4	26.1	2720	70,992
9	Сэлэнгэ сумын мод бэлтгэлийн талбай	200	19.4	38.8	2720	105,536
10	Сэлэнгэ – Хялганат тосгон	26	19.4	5	2720	13,600
11	Хялганат тосгоны мод бэлтгэлийн талбай	150	19.4	29.1	2720	79,152
12	Хялганат - Булган	143	19.4	27.7	2720	75,344
Дүн		1346		260.9		709,648
9 сард зохион байгуулах төлөвлөгөөт хяналт шалгалтад зарцуулагдах зардал						
д/д	Зардал	Зарцуулах		Нэг бүрийн өртөг	Нийт өртөг	
1	Шатахуун	1346/100*19.4=261 л		2720 төг	709,648	
2	Томилолт хүн/өдөр	4 хүн * 10 хоног =40		90000 төг	3,600,000	
Дүн						4,309,648

ОРХОН АЙМАГТАЙ ХИЛ ЗАЛГАА СУМДЫН НУТАГ ДЭВСГЭРИЙН МОД БЭЛТГЭЛД ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ ЗАМЫН МАРШРУТ, ЗАРДАЛ

д/д	Сумын нэр	Зай /км/	Норм /л/ Бензин	Шатахууны хэмжээ /л/	Нэгжийн үнэ төг	Бүгд үнэ /төг/
1	Булган – Орхон сумын нутгаар	100	19.4	19.4	2720	52,768
2	Орхон - Булган	23	19.4	4.4	2720	11,968
3	Булган-Бугат сумын нутгаар	120	19.4	23.2	2720	63,104
4	Бугат – Хангал сумын нутгаар	150	19.4	29.1	2720	79,152
5	Хангал - Булган	113	19.4	21.9	2720	59,568
Дүн		506		98		266,560
10 сард зохион байгуулах урьдчилан сэргийлэх хяналт шалгалтад зарцуулагдах зардал						
№	Зардал	Зарцуулах		Нэг бүрийн өртөг	Нийт өртөг	
1	Шатахуун	506/100*19.4=98 л		2720 төг	266,560	
2	Томилолт хүн/өдөр	3 хүн * 7 хоног =21		90000 төг	1,890,000	
Дүн						2,156,560

НИЙТ ЗАРДАЛ

д/д	Хяналт шалгалтын чиглэл	Хяналт шалгалт хийх хугацаа	Нийт зардал
1	2	3	4
1	Уул уурхай чиглэлээр төлөвлөгөөт хяналт шалгалт хийх	6, 7, 8 дугаар сард	4,936,448
2	Шатахуун түгээх станцуудад төлөвлөгөөт шалгалт хийх	6 дугаар сард	1,732,432
3	Амьтны тухай хуулийн хэрэгжилтэд урьдчилан сэргийлэх шалгалт хийх	7 дугаар сард	5,391,408
4	Ойн мэргэжлийн байгууллагуудад төлөвлөгөөт шалгалт хийх	9 дүгээр сард	4,309,648
5	Орхон аймагтай хил залгаа сумдын нутаг дэвсгэрийн мод бэлтгэлд шалгалт хийх	10 дугаар сард	2,156,560
Нийт дүн			18,526,496

--o00o--